

ОРХОН АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 06 дугаар сарын 05

Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар

№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Төсөл арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Төлөвлөгөөний төсөв, эх үүсвэр	Төсвийн гүйцэтгэлийн хувь	Хэрэгжилтийн хувь	Тайлбар
							Он	Түвшин						
Салбарын үр дүн: Хүнсний аюулгүй байдлыг сайжруулна														
1.	3.4. Ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ	3.4.1. Хоршоо эрхлэгчдийг бодлогоор дэмжин, ажлын байрыг нэмэгдүүлнэ.	ТЖУЧ 3.4.6	3.4.1.1. Шинэ хоршоо-Чинээлэг малчин хөдөлгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, зээлийн дэмжлэгт хамруулах	Дэмжсэн хоршоодын тоо, Кластер үйлдвэрлэл, үйлчилгээ	Тоо	2023	-	хоршоо 25, кластер үйлдвэрлэл 1-ээс доошгүй	20 хоршоог дэмжиж, 4 хоршоонд зээл олгосон	950.0 УТ	402.3 УТ	96	“Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль, “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хойд бүсийн зөвлөгөөнийг Булган аймагт зохион байгуулж 200 гаруй малчид оролцсон. Орхон аймгаас хоршооны 20 төлөөлөл оролцож мэдээлэл авсан. “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар мал аж ахуйн чиглэлийн 102 гишүүнтэй 11 хоршоо шинээр байгуулагдаж, 4 хоршооны 12 малчин 402.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлд хамрагдан үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.
2.				3.4.1.2. “Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III”-ыг орон нутагт хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт	Хувь	2023	100	100	22 төлөвлөсөн ажлын 14-ыг хэрэгжүүлсэн	20.0 ОНТ	8.0 ОНТ ХХСан 422.7	63.6	Аймгийн Засаг даргын 2025 оны “Хоршооны салбарын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/339 дүгээр захирамжаар 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 7 зорилт 22 арга хэмжээ зохион байгуулахаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу хоршоодыг чадавхжуулах 5 удаагийн сургалтад давхардсан тоогоор 131 хүнийг хамруулсан.. Аймгийн хэмжээнд "Хоршоог хөгжүүлэх сан"-аас хөдөө аж ахуйн чиглэлийн 5 хоршоо 422.7 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан.
3.				3.4.1.3. Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг орон нутагт хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт	Хувь	2023	100	100	11 ажил төлөвлөнөөс бүрэн хэрэгжүүлсэн 7	20.0 ОНТ	8.0 ОНТ	58.3	Аймгийн Засаг даргын 2025 оны “Ахуйн үйлчилгээний салбарын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/452 дугаар захирамжаар 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 зорилт 11 арга хэмжээ зохион байгуулахаар батлагдсан. Төлөвлөгөөний дагуу Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар, Монголын Үсчин, гоо засалчдын холбоотой хамтран “Монголын Үсчин Гоо Сайхны Хөгжил – 2030” чуулганыг зохион байгуулсан. Тус чуулганаар 14 аймаг орон нутгийн холбоод, 10 гаруй байгууллагууд,

														250 гаруй мэргэжилтэн нар идэвх санаачилгатай оролцлоо. Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 64 хүн хамрагдсан. Үүнд: “Бикини ваксны - ONE TOUCH” сургалт, Дэлхийн аварга, Алтан цомын эзэн, Дэлхийн дасгалжуулагч МУ-н мастер А.Магнай амжилтад хүрсэн туршлагаасаа хуваалцсан.
4.		3.4.2. Өрхийн болон жижиг, дунд үйлдвэрийн зориулалттай зээлийн сан, хүртээмжийг нэмэгдүүлж, төсөл хөтөлбөрт хамрагдах, санхүүгийн зах зээлд гарах нөхцөлийг бүрдүүлнэ.	ТЖҮЧ 3.4.7, ТЖҮЧ 8.5.1	3.4.2.1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, үр дүнд хяналт үнэлгээ хийх	Олгосон зээлийн хэмжээ	Тб. төг	2023	1.0	1.4	900.0	1400.0 УТ	300.0 ОНТ 600.0 УТ	64.2	ЖДҮХС-аас 7 төсөлд 900.0 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэсэн.
5.					ЖДҮХС-аас хөнгөлөлттэй зээл авсан нийт аж ахуйн нэгжүүдэд хийсэн хяналт шинжилгээ	Тоо	2023	100	100	-	5.0 ОНТ	-	-	Хугацаа хүлээгдэж байгаа
6.				3.4.2.2. Орон нутгийн үйлдвэрлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг олон нийтэд таниулан сурталчлах, борлуулалтыг дэмжих үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	Зохион байгуулсан үзэсгэлэн худалдаа	Тоо	2023	2	1-ээс дээш	2 удаагийн үзэсгэлэн зохион байгуулсан	20.0 ОНТ	-	100	- Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааны хүрээнд Булган аймгийн төв талбайд “Түншлэл-Хамтын ажиллагаа” үзэсгэлэнг зохион байгууллаа. Үзэсгэлэнд Орхон аймгаас 25 үйлдвэрлэл үйлдвэрлэгчийг оролцуулсан. -Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга” хэлэлцүүлэг зохион байгуулсантай холбогдуулан хүнсний үйлдвэрлэл эрхлэгч 56 иргэн, аж ахуйн нэгж оролцсон үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан.
7.	4.3. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ	4.3.1. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр хангана.	ТЖҮЧ 2.4.1, ТЖҮЧ 8.5.1	4.3.1.1. Орон нутгийн хүнсний бүтээгдэхүүнийг хөгжүүлэх зорилгоор болзолт уралдаан зарлаж, шилдэг бүтээгдэхүүн хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээ, дэмжлэгт хамруулсан бүтээгдэхүүн	Тоо	2023	1	5	-	35.0 ОНТ	-	-	Хугацаа хүлээгдэж байна
8.			ТЖҮЧ 2.2.5, 2.5.5, 4.1.8	4.3.1.2. Хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхжуулах сургалт болон бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, сурталчлах өдөрлөг зохион	Зохион байгуулсан сургалт, туршлага судалсан	Тоо	2023	1 сургалт, 1 туршлага	1 сургалт өдөрлөг, 1 туршлага	2 сургалт	15.0 ОНТ	-	100	Хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэлийн салбарын бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, мэдээллээр хангах 2 удаагийн сургалт зохион байгуулсан. Сургалтад хүнсний худалдаа эрхлэгч 100 аж ахуйн нэгжийн 127, хоол үйлдвэрлэлийн 110 аж ахуйн нэгжийн 134 иргэн хамрагдсан.

				байгуулах, туршлага судлуулах,										
9.			ТЖҮЧ 2.2.5, ТЖҮЧ 2.5.5	4.3.1.3. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн ур чадварыг дээшлүүлэх, ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулах, улс бүсийн арга хэмжээнд дэмжин оролцуулах, чадавхжуулах сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ	Тоо	2023	Ура лда ан- 1, сург алт- 1 зохи он байг уулс ан.	Уралдаан 1-ээс доошгүй удаа, сургалтыг 2-оос доошгүй удаа	Уралда ан-1, Өдөрлөг арга хэмжээ- 1	20.0 ОНТ	7.0 ОНТ	100	Орхон аймгийн "Тогоочдын холбоо" ТББ-тай хамтран "ERDENET FOOD FESTIVAL" болон "Аймгийн аварга тогооч шалгаруулах" уралдааныг зохион байгуулсан. "ERDENET FOOD FESTIVAL" арга хэмжээнд аймгийн хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй 30 аж ахуйн нэгж байгууллага (ресторан, лоунж, кафе, цайны газар, үйлдвэрлэлийн зориулалттай нийтийн хоолны газар, хүнс үйлдвэрлэгчид, технологич, хоол зүйч нарын төлөөлөл) оролцлоо. Арга хэмжээнд Монгол хоолны соёлыг гадаад, дотоодод таниулах, зочлох үйлчилгээ, хотын соёлыг дээшлүүлэх, орон нутгийн брэнд хоол бий болгох зорилгоор амжилттай зохион байгууллаа. "АЙМГИЙН АВАРГА ТОГООЧ" шалгаруулах тэмцээнд Орхон аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын 47 тогооч 6 нэр төрөлд ур чадвараа сорин оролцож, 24 байрыг эзлүүлэн шагнаж урамшуулав. Мөн шагналт байр эзлээгүй оролцогчдод батламжийг дурсгал болгон гардуулж, 27 тогоочид бүсийн тэмцээнд орох эрх өгсөн. Бүсийн тэмцээн Архангай аймагт 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулагдана.
10.			ТЖҮЧ 8.5.1	4.3.1.4. Хүн амын хаврын хүнсний хэрэгцээнд махны нөөц бүрдүүлэх	Нөөцөд бэлтгэсэн махны хэмжээ, хаврын хэрэгцээг хангасан байдал	Тоо, хувь	2023	200 тн мах	200 тн мах , 15 хүртэл хувь	200 тн 21.5 хувь	620.0 ОНТ	400.0 ОНТ	100	Аймгийн хүн амын 2025 оны хаврын махны хэрэгцээнд /21.5 хувь/ эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагад нийцсэн үйлдвэрийн аргаар бэлтгэсэн үхэр, хонь, ямааны 200 тн мах бэлтгэсэн бөгөөд 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Баян-Өндөр сумын 29 цэгт, Жаргалант суманд 3 цэгт үхрийн мах 1 кг нь 12300, хонины мах 1 кг нь 10300, ямааны мах 1 кг нь 8300 төгрөгийн үнээр хэрэглэгчдэд хүргэсэн. Нөөцийн махыг сонгон шалгаруулалтад оролцож шалгарсан Эрдмийт ХХК бэлтгэн нийлүүлсэн.
11.			ТЖҮЧ 2.5.5, ТЖҮЧ 8.5	4.3.1.5. Хүнсний аюулгүй байдлын хяналтын чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийхэд дэмжлэг үзүүлэх.	1.Хүнсний аюулгүй байдлын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь 2. "Салбарын хяналт шалгалтын	Хувь	2023	63.0 хувь , 11 объ ект	75.0, 100	1. 90.5 2.77	20.0 ОНТ	10.0 ОНТ	83.8	Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 4 удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтыг эхний хагас жилд 44 объект буюу 77 хувьд хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар бага эрсдэлтэй 44 объект - Хууль сахин мөрдөлтийн түвшин 90.5хувь - Эрсдэл үүсэх магадлал 9.4 хувь - Зөрчлийн тоо 181 -Хяналт шалгалтын явцад нийт 181 зөрчил илрүүлж 105 зөрчлийг газар дээр арилгуулж үлдсэн зөрчлийг нь арилгуулахаар улсын ахлах байцаагчийн 12 заалт бүхий 2 албан шаардлага, улсын байцаагчийн 57 заалт

					2025 оны төлөвлөгөө" -нд тусгагдсан хяналт шалгалтын хэрэгжилт									бүхий 3 албан шаардлага хугацаатай хүргүүлсэн. Хүрсэн үр дүн: 2024 онтой харьцуулахад эрсдэл 4 хувиар буурсан, Хууль тогтоомжийн хэрэгжилт 4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
12.			ТЖҮЧ 2.5.5, ТЖҮЧ 8.6	4.3.1.6. Нийтээр тэмдэглэх баяр болон цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Зөрчил арилгасан байдал	Хувь	2023	65	75	70	20.0 ОНТ	-	93.3	Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 6 удирдамжийн дагуу урьдчилан сэргийлэх шалгалтыг нийт 235 аж ахуй нэгж, 132 иргэнийг хамруулсан. Хяналт шалгалтын явцад 340 зөрчлийг илрүүлэн газар дээр нь 294 зөрчлийг арилгуулан ажиллав. Илэрсэн зөрчилтэй холбогдуулан улсын байцаагчийн 32 заалт бүхий 6 албан шаардлага хугацаатай хүргүүлж, биелэлтэд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж зөрчлийг арилгуулсан. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, чанар, аюулгүй байдлын баталгаажилд болон хүнсний аюулгүй байдлын талаар зөвлөгөө өгч, 3 хяналтын чиглэлээр 5 төрлийн 250 ширхэг гарын авлага тарааж, цахим хуудсанд 3 удаа нийтэлсэн. Зөрчил өмнөх оноос 5 хувиар буурсан.
13.		4.3.2. Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалангийн хүрсэн түвшинг тогтворжуулан хөгжүүлнэ.	ТЖҮЧ 4.1.8, ТЖҮЧ 8.5.1, ТЖҮЧ 8.5.2	4.3.2.1. Өрхийн тариалан эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх	Дэмжлэгт хамрагдсан өрх	Тоо	2023	500	100	500	150.0 ОНТ	50.0 ОНТ	100	Өрхийн тариалалтыг дэмжих зорилгоор аймгийн Засаг даргаар 2025 онд өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөнд нийт 9 арга хэмжээ төлөвлөсөн. Хөтөлбөрийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд: 1.Төмс, хүнсний ногооны үрийн дэмжлэгт Баян-Өндөр сумын 500 өрхийг хамруулан, сургалт арга зүйгээр хангасан. Дэмжлэгт хамрагдсан өрхүүдэд нийт 25тн үрийн төмс, 500 ширхэг 4 төрлийн үрийн багц олгосон. Нэг өрхийн 250 м.кв талбайд тарихаар тооцож үр олгосон нь нийт 12.5 га талбайд төмс, хүнсний ногоо тариалсан. 2.Хүлэмжийн тариалалтыг дэмжих зорилгоор орон нутгийн төсвөөс 6*10 м харьцаатай 50 ширхэг хүлэмжийг худалдан авч, олгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 3.Жаргалант сум төмс, хүнсний ногооны үр шинэчлэх зорилгоор төмсний үр 30 тн, шар луувангийн үр 100 кг, шар манжингийн үр 50 кг, хүрэн манжингийн үр 50 кг, урт сонгинын үр 10 кг-ыг 80 хувийн хөнгөлөлттэй үнээр иргэдэд олгосон. Үүний үр дүнд 25 га талбайд төмс, 32 га талбайд шар лууван, 17 га талбайд шар манжин, 10 га талбайд хүрэн манжин, 2 га талбайд урт сонгино тарих үрээр дэмжсэн.

14.			ТЖҮЧ 4.1.8, ТЖҮЧ 8.5.1	4.3.2.2. Хүлэмжийн аж ахуйг дэмжин хөгжүүлэх	Дэмжлэгт хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж	Тоо	2023	100	20	50	100.0 ОНТ	176.1 ОНТ	100	Хүлэмжийн тариалалтыг дэмжих зорилгоор орон нутгийн төсвөөс 6*10 м харьцаатай 50 ширхэг хүлэмжийг худалдан авч, олгох ажлыг зохион байгуулан ажилласан. Жаргалант суманд 29, Баян-Өндөр сумын 21 иргэнд олгосон.
15.			ТЖҮЧ	4.3.2.3. Орон нутгийн үйлдвэрлэгчдийг "Намрын ногоон өдрүүд-2025" улсын нэгдсэн арга хэмжээнд оролцуулах	Оролцсон бизнес эрхлэгчид	Тоо	2023	7 аж ахуй н нэгж , 4 иргэ н	5-аас доошгүй	-	3.0 ОНТ	-	-	Хугацаа хүлээгдэж байна.
16.		4.3.3. Малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологи йн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ.	ТЖҮЧ 8.5.3	4.3.3.1. Үржлийн хээлтүүлэгч, хээлтэгч малд үзлэг ангилалт хянан баталгаажуулалт хийх, ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах	1.Үзлэг ангилалтад хамрагдах мал 2. Бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдэх мал	Тоо Хувь	2023	1. 40.0 мянг ан толг ой 2.1. 7 мянг ан толг ой.	1. 100 хувь, бог малын хээлтэгчи йн 60-аас доошгүй хувь, 2. 1.0 мянган толгой үхрийг бүртгэсэн байна.	1.100 хувь, бог малын хээлтэгч ийн 60 хувь 1. Хугацаа хүлээгд эж байна	10.0 ОНТ	4.3 ОНТ	100	1. "Малын генетик нөөцийн тухай" хууль, аймгийн Засаг даргын 2025 оны А/223 дугаар захирамжийн хүрээнд нийт 41.2 мянган толгой малыг үзлэг ангилалтад хамруулахаас хаврын үзлэг ангилалтад бог малын 719 толгой хээлтүүлэгчийг 100 хувь, 40.6 мянган толгой хээлтэгчийн 60.0 хувь 24.2 мянган толгой хээлтэгчийг хамруулан анги, чанарыг тодорхойлон ажилласан. 2. Баян-Өндөр, Жаргалант суманд Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр цэвэр үүлдрийн үхэр өсгөн үржүүлж байгаа 31 малчин өрхийн 1300 толгой үхрийн судалгааг гарган Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Малын генетик нөөцийн хэлтэст хүргүүлэн ажилласан.
17.			ТЖҮЧ 8.5.2, ТЖҮЧ 8.5.5	4.3.3.2. Малчдын өвөлжөө, хаваржааны бууцны хөлд ногоон тэжээл тариалж тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх	1. Тэжээлийн ургамал тариалсан талбайн хэмжээ 2. Тэжээлийн хангамжийн нэмэгдсэн хувь	Га	2023	-	20 га , 10	-	50.0 ОНТ	-	-	1. Монгол улсын Засгийн газрын 2025 оны 47 дугаар тогтоолоор батлагдсан Атар-IV тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд ХААИС-ийн Мал аж ахуй, биотехнологийн сургуультай хамтран Өвөлжөө, хаваржааны бууцны хөлд ногоон тэжээл тариалах сургалт зохион байгуулан ажилласан. Тус сургалтад Баян-Өндөр, Жаргалант сумдын 102 малчин хамрагдсан. Тэжээлийн ургамал тариалах хугацаа хүлээгдэж байна. 2. Хугацаа хүлээгдэж байна.
18.			ТЖҮЧ 8.5.2, 8.5.5	4.3.3.3. Аймаг өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх.	Өвс, тэжээлийн хэмжээ	Тн	2023	160 тн өвс, 50.0 тн тэжээл	100 хувь бүрдүүлнэ .	-	195.0 ОНТ	-	-	Аймаг, сумдын аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг бүрдүүлэхээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 277,0 сая төгрөгийг шийдвэрлүүлж, өвс, тэжээл худалдан авах тендер зарлагдаж, шалгарсан компанитай гэрээ байгуулан ажиллаж байна. Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл зохион байгуулалтын ажлыг 10 сард хүлээн авна. Хугацаа хүлээгдэж байна.

19.			ТЖҮЧ 8.5, 8.5.5	4.3.3.4. Худаг уст цэгийг шинээр гаргах болон сэргээн засварлаж малчдад эзэмшүүлэх	Засварласан болон шинээр гаргасан худгийн тоо, бэлчээрийн усан хангамжийн нэмэгдсэн хувь	Тоо, хувь	2023	Шинээр 1 худаг гаргаж, бэлчээрийн усан хангамж 87 хувьд хүрсэн.	Шинээр 1 худаг гаргаж, 2 худаг засварлаж, бэлчээрийн усан хангамж 87.5 хувьд хүргэнэ.	3	65.0 ОНТ	11.8 Баян-Өндөр сумын төсөв	100	Аймгийн хэмжээнд бэлчээрийн зориулалттай 87 худаг, уст цэг байгаагаас инженерийн хийцтэй худаг 81, усан сан 6 байна. Бэлчээрийн усан хангамж 87 хувьтай байна. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Баян-Өндөр сумын Шанд, Гээг, Зүйлийн хөндийн бэлчээрийн 3 худгийг 11.8 сая төгрөгөөр сэргээн засварласан. Үүний үр дүнд 42 өрхийн 5300 толгой мал усаар хангагдсан.
20.		4.3.4. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг өргөтгөх, сайжруулахад хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ.	ТЖҮЧ 8.5.3, 8.5.4	4.3.4.1. Өндөр шимт эрчимжсэн мал аж ахуйн чанар сайжирч, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх.	Хамрагдсан эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн тоо	Тоо	2023	66	20	33	6.0 ОНТ	-	100	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 15 иргэнд Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ-ын Хөдөө аж ахуйн тасагтай хамтран Малын үржил селект, зохистой дадлын талаар сургалт зохион байгуулсан. Зөгий, тахиа, гахай зэрэг туслах аж ахуй эрхлэгч 18 иргэнд эрчимжсэн аж ахуйн бодлого, цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар, сургалт зохион байгуулсан. Дээрх сургалтаар ЖДҮХС-ийн зээл, Шинэ хоршоо хөдөлгөөн, Атар IV аяны зээлийн мэдээллүүдийг танилцуулан мэргэжил арга зүйн зөвлөмж, зөвлөгөө өгч ажилласан.
Хэрэгжилтийн дундаж хувь:													90.6	